



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 13 өдөр

Дугаар 1/79

Хархорин сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 43 дугаар зүйлийн 43.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 оны төсвийн жилийн эцэст төрийн сангийн (100101855499) татан төвлөрүүлэлтийн дансанд төвлөрүүлсэн төсөл, хөтөлбөрийн зарцуулагдаагүй үлдэгдэл санхүүжилт болох 530,460,250.77 (таван зуун гучин сая дөрвөн зуун жаран мянга хоёр зуун тавин төгрөг, далан долоон мөнгө) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн 110101855405 тоот дансанд буцаан олгосугай.

2.Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 530,460,250.77 (таван зуун гучин сая дөрвөн зуун жаран мянга хоёр зуун тавин төгрөг, далан долоон мөнгө) төгрөгийг зориулалтын дагуу олгож, хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Төсвийн ерөнхий нягтлан бодогч (Ц.Мягмарсүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.БАТ-ЭРДЭНЭ

401100157